



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 4/411

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын “б”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төсөл /Ховд, Дарви, Дөргөн, Зэрэг, Чандмань, Жаргалант сум/, 5 дугаар багц ажлын гүйцэтгэгч “Хос мөнх дөл” ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:

Т.Баярт - Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын
дарга

Д.Чулуунтогтох - Зэрэг сумын Жижиг дунд үйлдвэр
хариуцсан мэргэжилтэн

Б.Бурмаа - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн
дарга:

Л.Батгэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

2. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх төсөл /Ховд, Дарви, Дөргөн, Зэрэг, Чандмань, Жаргалант сум/, 5 дугаар багц ажлыг захиалагчаас баталсан ажлын даалгаврын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Н.Ганзориг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН